




МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.3.4-т “... архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна” гэж, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2-т “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн бөгөөд уг зорилтын хүрээнд 2021-2030 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна. Тухайлбал,

1/“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.8-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ” гэж, 2.2.9-д “Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах ...” гэж;

2/Мөн уг арга хэмжээний 2.2.35-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна” гэж, 7.3.6-д “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна” гэж;

3/Түүнчлэн уг арга хэмжээний 7.3.9-д "... мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ" гэж, 7.3.13-т "Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн боомтыг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд (перкурсор)-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохой сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно" гэж тус тус заажээ.

3.Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.1.9-д "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж заасан.

4.Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1.9-д заасныг хэрэгжүүлэх үүднээс Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2025 онд боловсруулахаар "Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д тусгасан байна.

5.Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1961 онд баталсан Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 1971 онд баталсан Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, 1988 онд баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцид Монгол Улс нэгдэн орсон¹ бөгөөд үндэсний хууль тогтоомжийг эдгээр конвенцид нийцүүлэх үүргийг хүлээсэн байдаг.

1.2.Практик шаардлага

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль анх 2002 онд батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд 23 жил өнгөрсөн бөгөөд тус хууль нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой байна.

Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш 23 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон түүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн гаралт жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгааг тоон үзүүлэлт, судалгаанаас харж болно. Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль батлагдах үед буюу 2002 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон түүнтэй холбоотой гэмт хэрэг улсын хэмжээнд нийт 2

¹Монгол Улс Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцид 1999 онд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцид 2003 онд тус тус нэгдэн орсон.

бүртгэгдэж, шийдвэрлэгдэж байсан бол энэ тоо 2014 онд 62, 2015 онд 79, 2016 онд 98, 2017 онд 222, 2018 онд 200, 2019 онд 258, 2020 онд 204, 2021 онд 187, 2022 онд 230, 2023 онд 238 болж жил ирэх бүр өссөн дүнтэй гарчээ. Сүүлийн 7 жилийн байдлаар, 2017 онд 52, 2018 онд 61, 2019 онд 192, 2020 онд 159, 2021 онд 173, 2022 онд 221, 2023 онд 197 зөрчил гарсан байна.

Мөн 2024 онд 254 гэмт хэрэг, 265 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 8.8 хувиар, зөрчил 34.5 хувиар тус тус өсчээ.

2024 онд нийт 221 иргэн холбогдон шалгагдсанаас 87.8 хувь нь эрэгтэй, 12.2 хувь нь эмэгтэй байна.

Гадаад улсад хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт Монгол Улсын 49 иргэн хорих ял эдэлж байгаагаас БНХАУ-д 34, БНТУ-д 5, ХБНГУ-д 2, БНСУ-д 7, Япон Улсад 1 тус тус байна. Үүнээс бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн 1, 25 жил хорих ялаар шийтгүүлсэн 4, 20 жил хорих ялаар шийтгүүлсэн 3, 19 жил хорих ялаар шийтгүүлсэн 1, 12 жил хорих ялаар шийтгүүлсэн 1, 11 жил хорих ялаар шийтгүүлсэн 2, 10 жил хорих ялаар шийтгүүлсэн 4, 9 жил хорих ялаар шийтгүүлсэн 2, 8 жил хорих ялаар шийтгүүлсэн 4, 7 жил хорих ялаар шийтгүүлсэн 2, 5 жил хорих ялаар шийтгүүлсэн 11, 4 жил хорих ялаар шийтгүүлсэн 5 байна.

Түүнчлэн сүүлийн 7 жилд гадаад улсын 12 иргэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шалгагдсанаас Нигер Улсын 1, БНХАУ-ын 1 иргэн 2-4 жилийн хорих ялаар шийтгүүлжээ.

Мөн 2006-2010 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн ихэнх хувийг манай оронд ургадаг мансууруулах үйлчилгээтэй олсны ургамлын төрлийн бодистой холбоотой гэмт хэрэг эзэлж байсан бол 2011 оноос химийн аргаар боловсруулсан буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт синтетик бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулаагүй хэдий ч санаатайгаар урвуулан ашиглаж мансуурах боломжтой эмийн хэрэглээ жил бүр өссөн байдаг. 2022 онд эд мөрийн баримтаар хурааж авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээг өмнөх онтой харьцуулахад каннабис 30 хувиар, гашиш 4,5 дахин, морфин 61,4 хувиар, DXM 2,7 дахин тус тус өсчээ. Хураан авсан каннабис ойл 371,7 граммаар, дроп 300 миллилитрээр, тебантин 56 ширхэгээр, DXM 25 ширхэгээр нэмэгджээ. Харин мөс 1,299.1 граммаар буюу 7 дахин буурсан байна.

Дээрх тоо баримт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилтыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зохицуулалт хангаж чадахгүй байгааг харуулж байна. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээ манай улсад өсөн нэмэгдэж байгаа нь хүний эрүүл мэнд болон улс орны үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засаг, соёлын үндэс, тогтвортой байдалд ноцтой аюул занал учруулж, үр дагавар нь тооцоолохын аргагүй нөхцөл байдалд хүргэж болзошгүйг ч анхаарах шаардлагатай болоод байна.

2.Сүүлийн жилүүдэд лабораторийн аргаар боловсруулсан, олон улсын гэрээнд тусгагдаагүй, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй шинэ төрлийн бодисууд гарсаар байгаа бөгөөд эдгээрийн нэр, төрөл улам олширч байна.

Мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ ихсэж, бэлтгэгч, худалдан борлуулагч, тээвэрлэгч, зуучлагч, хэрэглэгчийн сүлжээ үүсээд байна. Манай улсын хууль, эрх зүйн орчин бүрхэг, зохицуулалт дутмаг байгаагаас шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис нь олон улсын гэрээнд заасан жагсаалтад байхгүй гэдэг үндэслэлээр гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдалтай байна.

Иймээс манай улс мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын дотоодын жагсаалттай болж, олон улсын гэрээнд тусгагдаагүй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис болон урвуулан ашигласнаар мансууруулах үйлчилгээтэй, улмаар эрүүл мэнд, амь насанд эрсдэлтэй бусад бодисыг тус жагсаалтад тусгах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг ангилж, ангилал тус бүрд хууль ёсны болон хориглох эргэлтийн хэлбэрийг тодорхойлох шаардлагатай болжээ.

Мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын угтвар бодисыг хяналтад оруулах шаардлагатай байна.

3.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль ёсны эргэлтийг тодорхой зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэн, хаана, яаж, ямар зорилгоор хууль ёсны эргэлтэд оруулах нь тодорхой бус байгааг анхаарч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн байгууллагууд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг зөвхөн зөвшөөрлийн үндсэн дээр, төрийн байгууллага бүртгэлийн үндсэн дээр төрийн хяналт дор явуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай болжээ. Тухайлбал, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, амьтан барих үйл ажиллагаанд ашигладаг тайвшруулах, нойрсуулах, мэдээ алдуулах үйлчилгээтэй эм, бэлдмэлийг мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэлээр орлуулан бүртгэл, хяналтгүй, нуугдмал байдлаар ашиглах явдал гарч байна.

4.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамаарал бүхий хүнд эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах тогтолцоо, бүрэн эрх, чиг үүргийн зохицуулалтыг боловсронгуй болгох, уялдуулах шаардлагатай болжээ.

5.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох гэмт хэргийг мөрдөн шалгах, зөрчил шалгах дагнасан чиг үүрэг бүхий байгууллагатай болох, дундын мэдээллийн нэгдсэн цахим сан, системтэй болох, үүгээр дамжуулан төрийн байгууллага хооронд мэдээллийг шуурхай солилцож, шаардлагатай арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх шаардлага нийгмийн нөхцөл байдлаас урган гарч байна.

6.Нэгдсэн Үндэсний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гишүүн улс бүр мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүний хор уршгийг арилгах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг идэвхтэй зохион байгуулах шаардлагатайг сануулж, энэ чиглэлийн ажлаа эрчимжүүлэхийг зөвлөсөн байна. Мөн тус албанаас 2010 онд гаргасан тайланд Монгол Улсыг хар тамхи “дамжин өнгөрүүлэгч улс” гэж дүгнэж байсан бол 2014 оны тайланд “хэрэглэгч улс” болсон тухай дурджээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус наймаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид заасанчлан үндэстэн дамнасан, нарийн зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх арга, зохион байгуулалт боловсронгуй болж, үндэсний аюулгүй байдалд аюул, занал учруулах шинжтэй болж байна.

7.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийг Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ болох Нэгдсэн Үндэсний Байгууллагын “Мансууруулах эмийн тухай” 1961 оны нэгдсэн конвенци, “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” 1971 оны конвенци, “Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” 1988 оны конвенциудад мөн нийцүүлэх нь зүйтэй байна.

Мөн хар тамхитай холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг судлан үзэж, гэмт этгээдэд хүлээлгэх хариуцлагыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, үйлчлэл, үйлдлийн хор уршиг болон бусад объектив талыг харгалзан зөрчил, гэмт хэргийг ялгамжтай, тодорхой тогтоож, хүлээлгэх хариуцлага, ял шийтгэлийн бодлогыг чангаруулах шаардлагатай байна.

Ийнхүү одоо мөрдөж байгаа хуулийн зохицуулалт цаг үеэсээ хоцорсны дээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбогдсон бүх үйлдэл, эс үйлдэхүйг хамарч хяналт тавьж, хариуцлага тооцож чадахгүйд хүрч байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг харгалзан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд бүрэн хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах, хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, хамааралт байдалд орсон хүнд эрүүл мэнд, сэргээн засах, нийгмийн хамгааллын цогц тусламж үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор тус хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1/нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулахтай тэмцэх хууль тогтоомж, хуулийн нэр томьёоны тодорхойлолт, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулахтай тэмцэх үйл ажиллагаанд баримтлах зарчмын тухай;

2/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулахтай тэмцэх төрийн бодлого болон төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бусаар эргэлтэд оруулахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийн тухай;

3/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын дотоодын жагсаалтын тухай;

4/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд төрөөс тавих хяналт, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хуульд зааснаас бусад тохиолдолд эргэлтэд оруулахыг хориглох тухай болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах зориулалтын тухай;

5/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага, зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам, зөвшөөрөл олгох журам, зөвшөөрлийн хугацаа, хугацааг сунгах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглох, зөвшөөрлийг хүчингүй болгох журам, зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайлан болон тайланг хадгалах журмын тухай;

6/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм, эмийн түүхий эд, эмийн үйлчлэх бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хилээр нэвтрүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах, эмийн сангаас олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг тарималжуулах, түүх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах, зэвсэгт хүчинд эмчилгээний зорилгоор ашиглах, мөн эрх бүхий байгууллага шинжилгээ, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах, улсын нөөц, мал, амьтны эмийг амьтан барих үйл ажиллагаанд ашиглах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хадгалах, тээвэрлэх, устгахад тавих шаардлага болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал устгах журмын тухай;

7/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай тэмцэх төрийн байгууллагын тогтолцоо, ялангуяа мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг судлах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох гэмт хэргийг мөрдөн шалгах болон зөрчил шалган шийдвэрлэх байгууллага буюу Хар тамхитай тэмцэх газар, Үндэсний хороо, хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуй, гадаад харилцаа, боловсрол зэрэг холбогдох бусад асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нутгийн удирдах болон бусад төрийн байгууллагын чиг үүргийн тухай;

8/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг сайн дурын шинжилгээний үндсэн дээр эрт илрүүлж сайн дурын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах тухай;

9/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон тус бодисын хамааралтай хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх арга хэмжээ, Сэргээн засах төвийн тухай;

10/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сан, сангийн төрөл, түүнд оруулах мэдээллийн тухай;

11/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны тухай;

12/мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас урьдчилан сэргийлэх, хууль бусаар эргэлтэд оруулахтай тэмцэх талаар хүн, хуулийн этгээдийн

үүрэг, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг зохицуулах, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болж, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна. Үүнд:

1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, түүний зорилт, хэрэгжүүлэх үндсэн зарчим тодорхой болно. Мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдал хангагдаж, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийт, ялангуяа хүүхэд, залуучуудад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар таниулах эрх зүйн орчин боловсронгуй болно;

2.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүх үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг хуульд тодорхой тусган, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хийдлийг арилган, үйл ажиллагаа явуулах нөхцөл, шаардлагыг тодорхой болгоно;

3.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдон шийтгүүлж байсан этгээд суллагдсаны дараа тодорхой хугацаанд хяналт тогтоох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг бий болгоно;

4.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, мансуурах донтой хүнд стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах зохицуулалт бий болно;

5.Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, мансуурах донг эмчлэх шинэ арга, ажиллагааны талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж нэмэгдэнэ;

6.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах, үр дүнг үнэлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээнд тогтмол судалгаа, мониторинг хийх мэдээллийн нэгдсэн цахим сан бий болно;

7.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын зарцуулсан, худалдан борлуулсан эм, бэлдмэлийн тоо хэмжээ, зориулалтад хяналт тавих, тайлагнах журам хуульчлагдана;

8.Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, үйлчлэл, үйлдлийн хор уршиг болон бусад объектив талыг харгалзан гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийг хийдэлгүй, илүү тодорхой ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг чангаруулна;

9.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, тэдгээрийг таслан зогсоох ажилд ахиц, дэвшил гарах төдийгүй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх иргэдийн мэдлэг дээшилж, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамааралтай хүнд эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай болон хууль хоорондын уялдааг хангах зорилгоор шаардлагатай бусад хуулийн төслүүдийг боловсруулна.